

ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны
эрхлэх асуудлын хүрээнд/

2017.07.05

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн 2016 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ТУСГАЙЛАН ҮҮРЭГ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 68 хуулийн 262 заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 111 хуулийн 376 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн нь хяналтанд авсан нийт хуулийн 44 буюу 64.7 хувь, 204 заалт буюу 77.9 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үлдсэн 67 хуулийн 172 заалтын хэрэгжилтийн мэдээний хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх онуудад бүрэн хэрэгжиж, хяналтнаас хассан хуулиуд болно.

Давхардсан тоогоор 77 хуулийн 170 заалт буюу 45.3 хувь нь хэрэгжсэн, 56 хуулийн 148 заалт буюу 39.4 хувь нь хэрэгжих шатанд байгаа, 5 хуулийн 9 заалт буюу 1.5 хувь нь хэрэгжээгүй, 11 хуулийн 29 заалт буюу 7.8 хувь нь хугацаа болоогүй, 13 хуулийн 17 заалт буюу 4.5 хувь нь үнэлгээгүй, 2 хуулийн 2 заалт буюу 0.5 хувь нь хүчингүй болсон байна.

2.2. Монгол Улсын хуулиар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар

болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 15 хуулийн 86 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 39 хуулийн 147 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 30 хуулийн 50 заалт буюу 34.1 хувь нь хэрэгжсэн, 18 хуулийн 69 заалт буюу 46.9 хувь нь хэрэгжих шатандаа, 4 хуулийн 8 заалт буюу 5.4 хувь нь хэрэгжээгүй, 3 хуулийн 11 заалт буюу 7.5 хувь нь хугацаа болоогүй, 2 хуулийн 3 заалт буюу 2.0 хувь нь хүчингүй болсон байна. Харин 3 хуулийн 6 заалт буюу 4.1 хувь нь үнэлгээгүй гэж тооцсон.

Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	Хууль	Заалт	
	/давхардсан тоогоор/	Тоо	Хувь
Хяналтанд авсан	15	86	100.0
Үүнээс:			
- Хэрэгжсэн	12	24	27.9
- Хэрэгжих шатанд	7	40	46.6
- Хэрэгжээгүй	5	13	15.1
- Үнэлгээгүй	1	1	1.1
- Хугацаа болоогүй	1	8	9.3
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн			
Үүнээс:			
- Хэрэгжсэн	30	50	34.1
- Хэрэгжих шатанд	18	69	46.9
- Хэрэгжээгүй	4	8	5.4
- Хүчингүй болсон	2	3	2.0
- Хугацаа болоогүй	3	11	7.5
- Үнэлгээгүй	3	6	4.1

2.3. Мэдээнд гарсан зөрчил

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн хуулийн хэрэгжилтийн мэдээнд 2012-2015 онуудад хэрэгжсэн хуулийн заалтыг дахин ирүүлсэн, мөн 2016 оны хагас жилийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн 2 хуулийн 4 заалтын хэрэгжилтийг “хэрэгжих шатанд байгаа” гэж үнэлэн, хэрэгжилтийг бууруулан ирүүлсэн байна. Үүнд:
 - “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.8, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт;
 - “Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4 дэх заалтууд байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

2016 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их

Хурлын нийт 83 тогтоолын 303 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын нийт 74 тогтоолын 194 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн бөгөөд 9 тогтоолын 109 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 74 тогтоолын 194 заалтын 98 заалт буюу 50.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 73 заалт буюу 37.6 хувь нь хэрэгжих шатанд, 11 заалт буюу 5.7 хувийн хэрэгжих хугацаа болоогүй, 2 заалт буюу 1.0 хувь хэрэгжээгүй, 10 заалт буюу 5.2 хувь нь үнэлгээгүй ирүүлсэн байна.

3.2. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын 8 тогтоолын 18 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын 8 тогтоолын 17 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 5 тогтоолын 9 заалт буюу 52.9 хувь нь хэрэгжсэн, 5 тогтоолын 8 заалт буюу 47.1 хувь нь хэрэгжих шатанд байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	8	18	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	8	17	94.4
Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	1	1	5.6
Үүнээс:			
- Хэрэгжсэн	5	9	52.9
- Хэрэгжих шатанд байгаа	5	8	47.1

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 2012 оны Улсын Их Хурлын “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 2.1 дэх заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 93 тогтоолын 505 заалтыг хяналтанд авснаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2016 оны жилийн эцсийн байдлаар 55 тогтоолын 272 заалтын буюу хяналтанд авсан нийт заалтын 53.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 55 тогтоолын 272 заалтаас 42 тогтоолын 121 заалт буюу 44.4 хувь нь хэрэгжсэн, 37 тогтоолын 92 заалт буюу 33.8 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 8 заалт буюу 2.9 хувь нь хэрэгжээгүй, 7 тогтоолын 40 заалт буюу 14.7 хувь нь хэрэгжих хугацаа болгоогүй бол 8 тогтоолын 11 заалт буюу 4.04 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

4.2. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг өгсөн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 13 тогтоолын 115 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 8 тогтоолын 64 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 6 тогтоолын 26 заалт буюу 40.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 6 тогтоолын 27 заалт буюу 42.2 хувь нь хэрэгжих шатандаа, 2 тогтоолын 6 заалт буюу 9.3 хувь хэрэгжээгүй, 3 тогтоолын 5 заалт буюу 7.9 хувь хугацаа болоогүй гэж ирүүлсэн боловч давхардсан тоогоор 9 тогтоолын 51 заалт буюу 44.4 хувийнх нь мэдээг ирүүлээгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	НББСШУБХ-ны тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	13	115	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	5	51	44.4
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	8	64	55.6
Үүнээс:			
- Хэрэгжсэн	6	26	40.6
- Хэрэгжих шатанд	6	27	42.2
- Хугацаа болоогүй	3	5	7.9
- Хэрэгжээгүй	2	6	9.3

4.3. Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй

1. 2010 онд “Нийслэлийн Улаанбаатар хотын утаа, агаарын бохирдолтыг багасгах арга хэмжээний талаар” Төсвийн байнгын хороотой хамтран баталсан 01/03 дугаар тогтоолын 2 дахь заалт;
2. “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2010 оны 15 дугаар тогтоолын 1.1, 1.2, 1.3, 2.1, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7 дахь заалт;
3. “Нийслэлийн амаржих газруудын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд авах арга хэмжээний тухай” 2010 оны 07 дугаар тогтоолын 3 дахь заалт;
4. “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2012 оны 09 дүгээр тогтоолын 8 дахь заалт;
5. “Эмнэлгийн барилга, эзэмшил газрын талаар цаашид авах арга хэмжээний тухай” 2014 оны 09 дүгээр тогтоолын 5, 6, 7 дахь заалт;
6. “Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх тухай” 2014 оны 13 дугаар тогтоолын 1, 2, 3, 4 дэх заалт;
7. “Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархлалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх

талаар авах арга хэмжээний тухай” 2016 оны 10 дугаар тогтоолын 1.2 дахь заалт;

8. “Инновацийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2017 оны 18 дугаар тогтоолын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16 дахь заалт зэрэг болно.

4.4. Мэдээнд гарсан зөрчил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 04/04 дугаар тогтоолын 1.3, 1.4 дэх заалтыг дахин ирүүлсэн байна.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн дараах хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна. Үүнд:

Монгол Улсын 30 хуулийн 50 заалт, Улсын Их Хурлын 5 тогтоолын 9 заалт, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 6 тогтоолын 23 заалтын мэдээг ирүүлсэн байна.

Хууль тогтоомж	Хууль тогтоомжийн тоо	Заалтын тоо
Монгол Улсын хууль	30	50
Улсын Их Хурлын тогтоол	5	9
Байнгын хорооны тогтоол	6	23

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийж, үнэлээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулан тайлбарлаагүй, хэрэгжилтийн явцыг тоочих байдлаар нэгтгэн ирүүлсэн байна.

2/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

3/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд 2012-2015 онд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах санал ирүүлж, холбогдох Байнгын хороонд танилцуулсан хууль тогтоомжийн заалтыг дахин ирүүлсэн зэрэг дутагдалдаа дүгнэлт хийж ажиллах нь зүйтэй байна.

4/ Мэдээллийн сангийн хяналтаас хасах саналтай Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн нийт 35 хуудас жагсаалтыг хавсаргав.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**НИЙГМИЙН БОДЛОГО БОЛОВСРОЛ,СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНД ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 2008.05.22	30.3.Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх журмыг эрүүл мэндийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. /энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/	Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/234 тоот тушаалаар “Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх журам”-ыг баталсан.
2	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай 2011.07.09	11.3.Засгийн газраас тодорхойлсон дээд боловсролын салбарын талаар баримтлах чиглэл, шаардлагад нийцүүлэн төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/150 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралтаар Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд хэрэгжүүлэх “Дээд боловсролын байгууллагын хөгжлийг дэмжих төслийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх журам”, “Судалгааны тэтгэлэг олгох журам”-ыг тус тус баталсан.
3	Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай 2012.09.04	6.2. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан иргэний нэгдсэн бүртгэл, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төвлөрүүлэх журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийгмийн даатгалын үндэсний зөвлөлтэй зөвшилцөн батална.	“Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулийн төслийг хэлэлцүүлэн УИХ 2012 оны 09 дүгээр сарын 04-ны өдөр баталсан. Хуулийн 6.2-т заасныг үндэслэн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/57 тоот тушаалаар “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулах иргэний нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх журам”-ыг баталсан. Уг хуулиар нийт 602.5 мянган иргэний тасарсан ажилласан жил, төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцож 37.0 тэрбум төгрөгийн шимтгэлийг тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлсэн. Эдгээр иргэдэд тэтгэвэр олгоход тэтгэврийн даатгалын сангаас 2014-2016 онд 94 тэрбум төгрөгийг зарцуулсан.

4	<p>Нийгмийн халамжийн тухай /шинэчилсэн найруулга/ 2012.01.19</p>	<p>3.10.Энэ хуулийн 13.9-д заасан сургалтыг зохион байгуулах журам болон сургалтын хөтөлбөрийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.</p>	<p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2012 оны 165 тоот тушаалын хавсралтаар "Асаргаа, сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам"-ыг батлан хэрэгжүүлж байна. Сургалтын зорилго нь эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэн болон тэдний гэр бүлийнхэнд хэрхэн асаргаа, сувилгаа, асрамж, халамж үзүүлэх тухай мэдлэг, ур чадвар, хандлага олгоход чиглэдэг.</p>
		<p>19.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах үйлчилгээ, өдрийн үйлчилгээг үзүүлэх, тухайн хүүхдийг хөгжүүлэх төв, төрөлжсөн асрамжийн үйлчилгээг холбогдох стандартын дагуу зохион байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх асуудлыг нийгмийн халамжийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран шийдвэрлэнэ.</p>	<p>Сангийн сайд, Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 247/А/163 хамтарсан тушаалаар "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж норматив", "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хувцас, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэлийн зардлын дундаж норматив эдэлгээний хугацаа", "Төрөлжсөн асрамжийн газарт зайлшгүй байх эмийн жагсаалт"-ыг хавсралтаар тус тус батлан улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 8 асрамжийн газарт асруулж буй иргэдийн дээрх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байна. Мөн төрөлжсөн асрамжийн үйлчилгээг стандартын дагуу үзүүлж байгаа болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас зохион байгуулдаг сонгон шалгаруулалтад тэнцэн, гэрээ байгуулсан хувийн хэвшлийн "Бат гэрэлт ирээдүй" ТББ, "Ачлалт хүүхдүүд" ТББ-ын дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны асрамжийн газруудад асруулж буй иргэдийн хоол, хувцас, зөөлөн эдлэл, эм тарианы зардлын санхүүжилтийг олгон дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.</p>
5	<p>Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2012.10.26</p>	<p>43.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, бусад албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгох бөгөөд уг урамшууллын хэмжээ, түүнийг олгох журмыг төрийн албаны тухай хуулийн 31.3-т заасны дагуу Засгийн газар батална.</p>	<p>Төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшил олгох журмыг Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 393 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан.</p>

6	<p>Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2012.12.21</p>	<p>8.4.23. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах. 12.10. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн төлөөлөлд ажил олгогчийн төлөөлөл байх ба удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 03 дугаар сарын 26-ны А/130 тоот тушаалаар Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журмыг баталсан. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн даргын 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 001 дугаар тогтоолоор "Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага"-ыг батлууллаа.</p>
7	<p>Сэтгэцийн эрүүл мэндийн тухай /шинэчилсэн найруулга/ 2013.01.03</p>	<p>9.3. Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам, хугацааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p>	<p>Эрүүл мэндийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 30-ны 180 дугаар "Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай" тушаалын нэгдүгээр хавсралтаар сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журмын баталсан.</p>
8	<p>Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2013.02.07</p>	<p>3.19.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах үйлчилгээ, өдрийн үйлчилгээг үзүүлэх, тухайн хүүхдийг хөгжүүлэх төв, төрөлжсөн асрамжийн үйлчилгээг холбогдох стандартын дагуу зохион байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх асуудлыг нийгмийн халамжийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран шийдвэрлэнэ.</p>	<p>Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 247/А/163 хамтарсан тушаалаар "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж норматив", "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хувцас, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэлийн зардлын дундаж норматив эдэлгээний хугацаа", "Төрөлжсөн асрамжийн газарт зайлшгүй байх эмийн жагсаалт"-ыг хавсралтаар тус тус батлан улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 8 асрамжийн газарт асруулж буй иргэдийн дээрх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байна. Мөн төрөлжсөн асрамжийн үйлчилгээг стандартын дагуу үзүүлж байгаа болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас зохин байгуулдаг сонгон шалгаруулалтад тэнцэн, гэрээ байгуулсан хувийн хэвшлийн "Бат гэрэлт ирээдүй" ТББ, "Ачлалт хүүхдүүд" ТББ-ын дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны асрамжийн газруудад асруулж буй иргэдийн хоол, хувцас, зөөлөн эдлэл, эм</p>

			тарианы зардлын санхүүлжилтийг олгон дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.
9	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 2013.02.07	2.39.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай эм олгох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 129/100 дугаар тушаалаар батлагдсан. Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журмын дагуу нэгдсэн эмнэлэг, БОЭТ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, дүүргийн эрүүл мэндийн төвүүд эмнэлгийн төсөвт тусган олгож байна.
10	Хаягжуулалтын тухай 2013.02.07	4.6. Хаягийн тэмдэглэгээний стандартыг газрын харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.	2016 онд Стандартчилал, хэмжил зүйн газар "Нэгдсэн хаягжуулалт, хаягийн бичвэрт тавих шаардлага MNS 6275:2016 стандартыг баталж, мөрдүүлж байна. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор "Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ыг баталсан. Хаягжуулалтын ажлын хүрээнд "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5283:2014 стандартыг боловсруулан бүх яамдууд болон холбогдох агентлаг, байгууллагуудаас санал авч тусган Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014.02.27-ны өдрийн 01-р тогтоолоор баталгаажуулсан.
		4.7. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.	Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлуулсан.
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2013.02.07	7.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол олгох сургалтын стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, стандартчиллын төв байгууллага батална.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Монгол Улсын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль хүчингүй болсон хэрэгжилтийг хангах боломжгүй байх тул unelgee.gov.mn-д оруулсан тус хүчингүй болсон хуулийн 2.7.7, 3.6.4, 3.6.5, 4.7.10, 6.10.4 дэх заалтуудыг хяналтаас хасах саналтай байна. 2016 онд Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага MNS 6620:2016 стандартыг баталсан.
12	Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2013.02.07	18.9.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг энэ хуулийн 18.8-д заасны дагуу магадлан итгэмжлэх журмыг	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 05 сарын 02-ны өдрийн А/52 тушаалаар баталсан.

		нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”	
13	Соёлын өвийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ 2014.05.15	40.5.Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчийг жил бүр тодруулж, мөнгөн шагнал олгох бөгөөд мөнгөн шагнал олгох журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2016 оны “Журам батлах тухай” 145 дугаар тогтоолоор батлуулсан.
		51.2.Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журмыг Засгийн газар тогтооно.	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолоор “Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам”-ыг батлууллаа. Өмнө нь буюу Засгийн газрын 2003 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг зөөж тээвэрлэх журам”-аар зөвхөн төрийн өмчид байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийн хүрээнд буюу музей, номын сан, архивт хадгалагдаж байгаа хөдлөх дурсгалт зүйлийг зөөж тээвэрлэх үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан бол энэхүү шинэчлэн боловсруулсан журамд “түүх соёлын үл хөдлөх дурсгал болон түүний бүрэлдэхүүн хэсэгт хамаарах дурсгал”-ыг зөөж тээвэрлэх асуудлыг нэмж тусган Соёлын биет өвийн хүрээнд мөрдүүлэх юм.
		9.1.Соёлын биет өвийн үнэлгээ хийх журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	БНМАУ-ын Соёлын яамны /хуучин нэрээр/ сайдын 1984 оны 3 сарын 17-ны өдрийн 94 дүгээр тоот тушаалаар “Үнийн үлгэрчилсэн жагсаалтыг батлах тухай” журам батлагдаж, тус онд музейн үзмэрийн үнийг өөрчлөн тогтоосон байдаг. 1990 онд музейнүүдийн үзмэрийн бүртгэлийн үнийг тухайн үеийн швейцар франкийн ханш руу шилжүүлсэн байдаг боловч энэ ажиллагааг гүйцэтгүүлэх тухай эрх зүйн баримт бичиг олдохгүй байна. 2003, 2010 оны Төрийн өмчийн хорооны тооллогоор зарим музейн барилга, ширээ, сандал зэрэг үндсэн хөрөнгийн үнийг дахин үнэлсэн боловч улс, орон нутгийн музейн үзмэрийг бүрэн хамруулаагүй. Улс, орон нутгийн музейн үзмэрийг санхүүгийн тайлагналын зорилгоор үнэлэх аргачлалыг боловсруулсан. “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийг үнэлэх журам”-ыг боловсруулахдаа бүртгэлийн үнийг тогтоохдоо тухайн зүйлийн түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, ховор,

			<p>түгээмэл байдал, материал, бүтээсэн он цаг, ур хийц, арга ажиллагаа, жин, хэмжээ, иж бүрдэл, гэмтэл, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол зэргийг харгалзан үлгэрчилсэн үнийг тодорхой хувиар өсгөж буруулах боломжтой болгох зэрэг зарчмыг баримталсан болно.</p> <p>Уг журмын төсөлд Сангийн яамны бүх газрууд болон Дүрслэх урлагийн музей, Байгалийн түүхийн музей, Үндэсний музей, Төрийн өмчийн хороонд 2013 оны 3 дугаар сарын 19-ний албан бичиг хүргүүлэн саналыг авч, судлан журамд тусгаад байна.</p> <p>Журмын төслийг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны дэргэдэх “Түүх,соёлын дурсгалт зүйлсийн зэрэглэл, үнэлгээг тодорхойлох мэргэжлийн зөвлөл”, “Улс орон нутгийн музейн сан хөмрөгт улсын тооллого явуулах төв комисс”-оор хэлэлцүүлсэн.</p> <p>Мөн улс, орон нутгийн музейн сан хөмрөгт улсын тооллогын төв комиссоос Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн, Чойжин ламын сүм, Хар хорум, Хөшөө цайдам, Эрдэнэ зуу, Төв, Өмнөговь, Архангай зэрэг 8 музейн сан хөмрөгийн 480 дэсийн 600 үзмэрт бүртгэлийн шинэчилсэн үнэлгээг туршиж үзсэний дүнд Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” 140 дүгээр тушаалаар батлуулав.</p> <p>Сангийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаалаар батлагдсан “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлсийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”-ыг олон улсын гэрээ, конвенци, үндэсний хууль тогтоомжтой уялдуулан шинэчлэн боловсруулж холбогдох байгууллага, эрдэмтэн судлаачдаас санал авсан.</p>
14	Номын сангийн тухай 2014.12.19	8.1.Үндэсний номын сангийн дэргэд орон тооны бус эрдмийн зөвлөл болон мэргэжлийн зөвлөл ажиллах бөгөөд эрдмийн зөвлөл болон мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны Сайдын 2015 оны А/200 дугаар тушаалаар “Номын сангийн эрдмийн зөвлөлийн ажиллах журам”, “Номын сангийн мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам” батлагдсан.

		19.2.Номын сангийн сан хөмрөгийн бүртгэл, тооллого хийх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/500 дугаар тушаалаар “Номын сангийн сан хөмрөгийн бүртгэл, тооллого хийх журам” батлагдсан.
		20.5. Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн "Журам батлах тухай" 288 дугаар тогтоолоор “Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг баталсан.
15	Эрүүл мэндийн даатгалын тухай /шинэчилсэн найруулга/ 2015.01.29	20.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн анхан шатны нягтлан бодох бүртгэлийн маягтын загварыг санхүү, төсвийн болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар 2017 оноос Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг бие даасан байгууллага болгохоор хуульчилсны дагуу эрүүл мэндийн даатгалын сан мөн нийгмийн даатгалын бусад сангаас тус хуулийн 20.4 дэх хэсэгт "Эрүүл мэндийн даатгалын сангийн анхан шатны нягтлан бодох бүртгэлийн маягтын загварыг санхүү, төсвийн болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэж заасан. Гэвч 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэхээр өөрчилсөн тул эрүүл мэндийн даатгалын сан нийгмийн даатгалын сангуудын нэг бүрэлдэхүүн хэвээр байгаа тул өнөөдөр мөрдөж буй Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны Маягт, заавар батлах тухай 76/36 тоот хамтарсан тушаалыг дагаж мөрдөж байгаа болно. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг бие даалган хөгжүүлэхээр тусгасан боловч улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой бие даалгах асуудлыг хойшлуулсан. Иймд тус загварыг дахин батлахгүйгээр хуучин загвараар хэрэгжиж байна.
		22.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагч, шимтгэл төлөлт, даатгуулагчид үзүүлсэн эрүүл	Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн "Дүрэм, журам, загвар батлах тухай" 279 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн

		<p>мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сан /цаашид “мэдээллийн цахим сан” гэх/-тай байх бөгөөд мэдээллийн цахим сангийн дүрмийг Засгийн газар батална.</p>	<p>цахим сангийн дүрэм”-ийг баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 13 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2016 оны хэмжээг тогтоох тухай” тогтоол батлагдан мөрдөж байна. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 279 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн цахим сангийн дүрэм” батлагдсан.</p>
		<p>22.6. Цахим картын загвар, цахим картад хадгалагдах мэдээлэл, цахим картыг хэрэглэх журмыг үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн “Дүрэм, журам, загвар батлах тухай” 279 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Эрүүл мэндийн даатгалын цахим картад хадгалагдах мэдээлэл болон цахим картыг хэрэглэх журам”-ыг, 3 дугаар хавсралтаар “Эрүүл мэндийн даатгалын цахим картын загвар”-ыг тус тус баталсан. Тус 279 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн цахим сангийн дүрэм”, “Эрүүл мэндийн даатгалын цахим картад хадгалагдах мэдээлэл болон цахим картыг хэрэглэх журам”, “Эрүүл мэндийн даатгалын цахим картын загвар” тус тус батлагдан мөрдөж байна.</p>
<p>16</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 2015.01.29</p>	<p>1.2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан эрүүл мэндийн даатгалын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8.1 дэх хэсгийг хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 183 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2015 оны хэмжээг тогтоосон. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар тогтоосон. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцдаг иргэн, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч, малчин, ял эдэлж байгаа хоригдол болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.11-д заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг тус тус 670 (зургаан зуун далан) төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 6 хувьтай тэнцүү байхаар тогтоосон. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 13 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын</p>

			шимтгэлийн 2016 оны хэмжээг, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 197 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2017 оны хэмжээг тогтоож мөрдөн ажиллаж байна.
		1.2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан эрүүл мэндийн даатгалын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6.1.9-д заасан даатгуулагч шимтгэлээ 2016 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн өөрөө хариуцан төлөх бөгөөд 2016 оны 01 дүгээр сарын 01-ийг хүртэлх хугацаанд мөн хуулийн 6.1.9-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцан төлнө.	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн "Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2016 оны хэмжээг тогтоох тухай" 13 дугаар тогтоолоор дараах хувь хэмжээг тогтоосон. 1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.1-д заасан ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь 2. Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч болон 0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 1920 (нэг мянга есөн зуун хорин) төгрөгөөр, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтан болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.12 дахь заалтаар иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 3840 (гурван мянга найман зуун дөчин) төгрөгөөр тогтоон хэрэгжүүлэн ажилласан.
		22.1.Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагч, шимтгэл төлөлт, даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сан /цаашид "мэдээллийн цахим сан" гэх/-тай байх бөгөөд мэдээллийн цахим сангийн дүрмийг Засгийн газар батална.	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны А/58 тоот тушаалаар даатгуулагч, шимтгэл төлөлт, даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сангийн дүрэм, цахим картын загвар, цахим картад хадгалагдах мэдээлэл, цахим картын хэрэглэх журмын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ХАХНХЯ, ЭМСЯ, СЯ, НДҮЗ, НДЕГ, УБЕГ, МТШХХГ, МАОЭНХ, МҮЭХ зэрэг байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.

17	<p>Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2015.01.30</p>	<p>2/16 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсэг: “9. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хувиар тооцон улсын төсвөөс жил бүр нийгмийн даатгалын санд төлнө. 10. энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын шимтгэлийг тооцох орлогын хэмжээ, шимтгэл төлөх журмыг Засгийн газар батална.”</p>	<p>Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 318 дугаар тогтоолоор Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-д нэмэлт оруулсан бөгөөд 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Цаатан иргэдийн шимтгэл 37.7 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд, 3.8 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын санд нэхэмжлэн, нийт 41.5 сая төгрөгийг хүлээн авч, Хөвсгөл аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэст шилжүүлж, цаатан иргэдийг нийгмийн даатгалд даатган ажиллаж байна.</p>
18	<p>Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 2015.01.30</p>	<p>“2. Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-3-т заасан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний 2 тэжээгч нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан 2 даатгуулагчийн авч байсан хөдөлмөрийн хөлсний нийлбэрээс энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хувь хэмжээгээр бодож тогтооно.” 2/22 дугаар зүйлийн 4 дэх хэсэг: “4.даатгуулагчийн 1995 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан ажил, мэргэжлийн жишиг цалинд үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлж болно.” 3/28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт: “2/авч байгаа тэтгэврийг нь</p>	<p>Монгол Улсын Засгийн газар 2014 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэн баталсан Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг ийнхүү шинэчлэн баталснаар иргэдийн тэтгэвэр нэмэгдэх боломжтой боллоо. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлж, ажилласан сүүлийн 20 жилийн доторх аль өндөр дараалсан 5 жилийн цалинг сонгон тэтгэврээ тогтоолгодог. Энэ сонгосон 5 жил нь магадгүй одоогоос 15 жилийн өмнөх цалин байж болох учраас тэр үед авч байсан цалинг өнөөгийн худалдан авах чадвартай дүйцүүлэх зорилгоор ИТГЭЛЦҮҮР гэсэн үзүүлэлтийг ашигладаг. Засгийн газраас ийнхүү итгэлцүүрийг шинэчлэн баталж тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авснаар тэтгэвэр авагчдын тэтгэврийн дундаж тэтгэвэр 222,9 мянган төгрөгөөс 326,0 мянган төгрөгт хүрсэн. Үүнээс гадна нэг ижил төрлийн ажил хөдөлмөр эрхэлж байсан боловч тэтгэвэр тогтоолгосон хугацаа нь өөр, өөр тэтгэвэр авагчийн хувьд тэтгэвэр нь харилцан адилгүй тогтдог байсан байдлыг залруулахад шинээр батлагдсан итгэлцүүр том ахиц гаргасан гэж дүгнэж байна.</p>

		тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлсний хэмжээг дүйцүүлэн тооцох итгэлцүүрийг Засгийн газраас шинэчлэн тогтоосонтой уялдуулан хөдөлмөрийн хөлсний хэмжээ өөрчлөгдөх үндэслэлтэй болсон нь тогтоогдож тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан бол зөвхөн нэг удаа;"	
19	Монгол хэлний тухай 2015.02.12	3.1.2. Их, дээд сургуульд элсэгчдээс авах элсэлтийн ерөнхий шалгалтын монгол хэлний шалгалтын агуулгыг энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын саналыг тусган батлах;	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдөр "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/87дугаар тушаалыг баталлаа. Уг тушаалаар 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр баталсан "Монгол хэлний тухай" хуулийн дагуу сурган хүмүүжүүлэх ухаан, хэл шинжлэл, уран зохиол, сэтгүүл зүйн чиглэлээр их, дээд сургуульд элсэгчдээс монгол хэл, бичгийн нарийвчилсан шалгалт авах тухай бүлгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар баталсан "Оюутан элсүүлэх журам"-д нэмж оруулан, дээд боловсролын сургалтын байгууллагуудад хариуцуулахаар шийдвэрлэсэн.
		13.1.3.Сурган хүмүүжүүлэх ухаан, хэл шинжлэл, уран зохиол, сэтгүүл зүйн чиглэлээр их, дээд сургуульд элсэгчдээс авах монгол хэл, бичгийн шалгалтын тусгайлсан журам боловсруулах;	Ерөнхий боловсролын сургууль төгсөгч болох их, дээд сургууль, коллежид элсэгчдээс монгол хэл, бичгийн нарийвчилсан шалгалт авах тухай асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдөр "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/87дугаар тушаалаар "Оюутан элсүүлэх журам"-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу дээд боловсролын сургалтын байгууллагууд дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон. Энэхүү журмын дагуу тухайн сургуулийн онцлог үйл ажиллагаанд нийцүүлж өөрийн сургуулийн "Оюутан элсүүлэх журам"-даа сурган хүмүүжүүлэх ухаан, хэл шинжлэл, уран зохиол, сэтгүүл зүйн чиглэлээр нарийвчилсан шалгалт авах талаар оруулж тусган мөрдөж байгаа.
		13.1.4. Суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг хос хэлний хөтөлбөрөөр явуулах бөгөөд хос хэлний хөтөлбөрийн агуулгыг батлах;	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2015 оны А/220 дугаар тушаалд "Суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнхөд зориулсан хос хэлний сургалтын бодлого, агуулга, хөтөлбөр боловсруулж, бэлтгэл ханган 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэх"-ээр

20	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2015.05.14</p>	<p>30.3.Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх журмыг эрүүл мэндийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>	<p>заасан. Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/234 дугаар тушаалаар “Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэн, мэдээлэх журам”-ыг батлуулсан. Журмын 1 дүгээр хавсралтаар “Мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэх, мэдээлэх журам”, 2 дугаар хавсралтаар “Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтныг бүртгэн, мэдээлэх маягт”, 3 дугаар хавсралтаар “Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг нэгтгэн мэдээлэх тайлангийн маягт”-ыг тус тус баталсан.</p>
		<p>27.6.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p>	<p>Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тоот тушаалаар, “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийг батлуулан мөрдөж байна.</p>
		<p>21.1.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг батлах;”</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дөрөв дэх хөтөлбөрийн хугацаанд дараах дүрэм, журмуудыг шинээр болон шинэчлэн боловсруулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоол “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”; - Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/61 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага шалгаруулах журам”; - Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/340 “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам батлах тухай”; - Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 “Зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив балах тухай”; - Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам батлах тухай”; - Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/295 “Ажлын байрны

			<p>эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж батлах тухай”;</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/234 “Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай”; - Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/33 “ХАБЭА-н сургалт зохион байгуулах, шалгалт авах журам”; - ХАБЭА-н Үндэсний хорооны 2016 оны 01 тогтоол “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх аргачлал”; - Монгол Улсын Шадар сайд, БХБ-ын сайд, Хөдөлмөрийн сайдын хамтарсан 2015 оны А/82/141/123 “Барилгын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах нийтлэг журам”; - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журмыг шинэчилж, Нийгмийн даатгалыг үндэсний зөвлөлийн 2013 оны 139 дүгээр тогтоолоор баталсан.
21	Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай 2016.01.22	6.1.1.Орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн хөнгөлөлт үзүүлэхэд шаардагдах зардлыг энэ хуулийн 3.2.4-т заасан орлогоос санхүүжүүлэх;	<p>Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг 2016 он 01 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас баталж, уг хуулийг дагалдан нэмэлт оруулсан Төсвийн тухай хуулиар тус сан нь бие даасан төсөвтэй байхаар заасан бөгөөд уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн 2016 оны төсвийг Төсвийн тухай хуульд заасан төсвийн цаглабарыг үл харгалзан батлах боломжтой байхаар тусгасан.</p> <p>Гэвч эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас Монгол Улсын 2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс ихээхэн хэмжээгээр буурахаар байсантай холбогдуулан энэхүү хуулийг 2016 онд хэрэгжүүлэхэд нийгэм, эдийн засгийн хувьд боломжгүй нөхцөл үүссэн.</p> <p>Иймд цаашид ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны өмчлөл болон түүний шаардах эрхийг хэрхэн оновчтой удирдах, ипотекийн зээлийг ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх</p>

			зэрэг асуудлыг шийдвэрлэтэл уг хуулийн үйлчлэх хугацааг хойшлуулан Ирээдүйн тэтгэврийн нөөц сан дах хөрөнгийг Монголбанкинд буцаан шилжүүлэхээр тогтсоны дагуу Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийн үйлчлэлийг 2019 оноос эхлэн дагаж мөрдөхөөр тогтсон.
22	Эрүүл ахуйн тухай 2016.02.04	4.7.Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийн стандартыг барилгын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран боловсруулж, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.	<p>Эрүүл мэндийн яамтай хамтран “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага. MNS 5924:2015” стандартыг шинэчлэн боловсруулж, Стандартчиллын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, 2016 оны 02 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. MNS EN 12566 2011, 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 1-р хэсэг: Угсармал септик; 2. MNS EN 12566-2:2011, 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 2-р хэсэг: Хөрсөөр шүүрүүлэх систем; 3. MNS EN 12566-3:2011, 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 3-р хэсэг: Угсармал болон газар дээр нь угсарсан ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж; 4. MNS EN 12566-4:2011, 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйнбохир ус цэвэрлэх байгууламж. 4-р хэсэг: Угсардаг иж бүрдлийг ашиглан газар дээр нь угсарсан септик; 5. MNS EN 12566-5:2011, 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 5-р хэсэг: Урьдчилсан цэвэрлэгээ хийсэн бохирыг шүүх шүүлтүүрийн систем; 6. MNS EN 12255; 1:2012 Бохир ус цэвэрлэх байгууламж. 1-р хэсэг: Хийцийн ерөнхий зарчмууд; 7. MNS EN 12255; 4:2012 Бохир ус цэвэрлэх байгууламж; 4-р хэсэг: Анхдагч тунгаагуур; 8. MNS EN 12255; 6:2012 Бохир ус цэвэрлэх байгууламж; 6-р хэсэг: Идэвхт лагийн процесс; 9. MNS EN 12255; 7: 2012 Бохир ус цэвэрлэх байгууламж; 7-р хэсэг: Бэхлэгдсэн хальс бүхий биологийн реактор;

			<p>10. MNS EN 12255; 10:2012 Бохир ус цэвэрлэх байгууламж; 10-р хэсэг: Аюулгүй ажиллагааны зарчмууд;</p> <p>11. MNS EN 12255 11:2012 Бохир ус цэвэрлэх байгууламж; 11-р хэсэг: Шаардлагатай ерөнхий өгөгдлүүд;</p> <p>12. MNS ISO 24511:2012 Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ; Ариутгах татуургын барилга байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшинг үнэлэх аргачлал;</p> <p>13. MNS ISO 24512 : 2012 Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ; Ус хангамжийн барилга, байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшинг үнэлэх аргачлал зэрэг олон улсын стандартуудыг үндэсний стандартаар батлан мөрдүүлж байна.</p>
		<p>4.9 .Хүн амын ундны ус, хүний амьдрах орчны агаар, хөрсний эрүүл ахуйн стандартыг эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран боловсруулж, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.</p>	<p>Уг стандартын төсөлд 17 байгууллагаас санал авч нэгтгэн, төслийг БОНХАЖЯ-аас санал авахаар хүргүүлээд байна.</p> <p>Уг стандартын төсөлд санал авахаар БОАЖЯ-нд албан бичгээр хүргүүлсэн ба холбогдох саналыг тусгахаар ажлын хэсэгт онлайнаар саналыг хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Агаарын стандартыг шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, стандартын төслийг батлуулахаар Стандартчилал хэмжил зүйн үндэсний газарт хүргүүлээд байна. "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS4585:2016” стандарт батлагдаж, 7-р сарын 8-ны өдрөөс эхлэн мөрдөж байна. - Хөрсний эрүүл ахуйн стандартын төсөлд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш нараас санал авч, Эрүүл ахуй, тархвар судлаачдын үндэсний III зөвлөлгөөнд оролцсон 360 гаруй оролцогчдоор хэлэлцүүлж, саналыг аваад байна. НМХГ, ШУТИС-ын багш нараас санал авсан. <p>2016 онд:</p> <ul style="list-style-type: none"> - Агаарын чанар Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх сорьц цуглуулалтанд ашиглах тоосны ширхэгийн хэмжээний фракцын тодорхойлолт MNS ISO 7708:2016; Агаарын чанар. Техникийн

		<p>6.4. Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн стандартыг эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран боловсруулж, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.</p>	<p>ерөнхий шаардлага MNS 4585:2016 улсын стандартыг шинээр баталсан.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын салбарт Стандартчилал хэмжил зүйн газраас 2015 онд баталсан “Сургуулийн өмнөх боловсрол сургалтын орчны стандарт” /MNS5420-1:2015/-ыг мөрдөж байна.</p> <p>“Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага”-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2016 оны А/253/251/173 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.</p> <p>Хуулийн энэ заалтын хүрээнд сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн стандартыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж ирүүлсний дараа тус яам хамтран хэрэгжүүлэх боломжтой.</p> <p>Мөн энэхүү заалтыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санаачлан боловсруулахаар байх тул хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Аж үйлдвэрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төрийн нарийн бичгийн дарга нарын 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 204/372 дугаар хамтарсан тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн ширээ, сандал, тавилгыг дотоодын үйлдвэрүүдэд үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх” стандартыг шинэчлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан.</p> <p>Сурагчийн ширээ ба сандал. Техникийн шаардлага MNS 6582:2016 болон Сурагчийн ширээ ба сандал.</p> <p>Турших стандарт MNS 6583:2016 стандарт тус тус батлагдаж, 2016 оны 9 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөж эхэлнэ. МХЕГ болон БХБЯ-нд ажлын хэсэгт оруулах ажилтны нэр ирүүлэх тухай 2016 оны 3 дугаар сард албан тоот хүргүүлэн, хамтарсан ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг 1 удаа хуралдаж, уг хуулийн 7.2-ын дагуу хийгдэж байгаа “сургалт хүмүүжлийн орчны үлгэрчилсэн дүрэм”-ийн төсөлтэй хэрхэн уялдуудах талаах МХЕГ, НМХГ-тай уулзалт хийхээр зөвшилцсөн.</p> <p>2016 онд: Сурагчийн ширээ ба сандал. Техникийн шаардлага</p>
--	--	--	--

			MNS 6582:2016 Сурагчийн ширээ ба сандал. Турших арга MNS 6583:2016 стандартыг баталсан.
23	Хүүхдийн эрхийн тухай 2016.02.05	14.2.Энэ хуулийн 14.1.6-д заасан сан бүрдүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	“Хүүхдийн эрхийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/228 тоот тушаалаар батлагдсан.
24	Хүүхэд хамгааллын тухай 2016.02.05	10.4.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/330 тоот тушаалаар батлагдсан.
		15.5.Хамтарсан багийн ажиллах журам, тухайн багийн гишүүдэд урамшуулал олгох журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны А/328 тоот тушаалаар батлагдсан.
		20.2. Нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм, түүнд тавих шаардлагыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэжлийн холбоодтой зөвшилцөн батална.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/229 тоот тушаалаар "Нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм" батлагдсан.
25	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 2016.02.05	10.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоол, үйлчилгээний заавал мөрдөх үндэсний стандартыг тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага. MNS 5012-2011 “Нийтийн тээвэр Замналын зогсоол”. Ангилал.Техникийн шаардлага: MNS 5879 2012 Эдгээр стандартуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг тусгасан.
		37.5. Энэ хуулийн 37.2.1-37.2.3-т заасан комиссын дүрмийг Засгийн газар батална.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн төсөл боловсруулагдсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн. 16 ба түүнээс дээш насны иргэний хөгжлийн бэрхшээлтэй

			эсэхийг тодорхойлох "Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс"-ын дүрэм Засгийн газрын 2015 оны 11 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан.
		41.2.Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41.1, 41.2 дахь хэсэгт заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 136 дугаар тогтоолоор баталсан бөгөөд зөвлөлийн хурал 2017 оны 1 дүгээр улиралд зохион байгуулагдана.
26	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016.04.14	11.5 Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан батална.	"Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын төлөвлөгөө, бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр"-ийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/301 дүгээр А/240 дүгээр, "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр"-ийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/301 дүгээр, "Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр"-ийг 2016 оны А/77 дугаар тушаалаар тус тус баталсан байна.
27	Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016.04.14	14.5.Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 333 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам"-д заасны дагуу гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулж ажиллахыг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосон байдаг. Энэхүү журмыг одоогоор сургалтын үйл ажиллагаанд хэвийн мөрдөн ажиллаж байна.
28	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016.04.14	15.5.Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын улсын төсвөөс санхүүжүүлэх хувь, хэмжээг Засгийн газар тогтооно."	"Хоолны зардлын дундаж норматив батлах тухай" Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 төгрөгөөр, 24 цагаар ажилладаг цэцэрлэг, сувиллын болон тусгай цэцэрлэгт 2400 төгрөгөөр тус тус тогтоосон болно.
29	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт	6.5.энэ хуулийн 6.4-т заасан жагсаалтад орсон тухайн бодисын бүртгэл хөтлөх, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, устгах,	Химийн хорт болон аюултай бодисын ангилал батлах тухай" Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан А/356/396 тушаал.

	<p>оруулах тухай 2011.10.06</p>	<p>импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.</p>	<p>“Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтарсан 2007.04.27-ны өдрийн 151/126/52 дугаар тушаалыг шинэчлэх ажлын хэсгийг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-228 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.</p> <p>БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-342 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж, “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам”-ын төслийг боловсруулсан.</p> <p>Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг олон улсад мөрдөгдөж байгаа ангилалтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, БОНХАЖС, ЭМСС-ын хамтарсан 2015 оны А/356/396 тушаалаар батлуулсан.</p> <p>“Микробиологийн сорьц тээвэрлэхэд тавигдах шаардлага” стандарт боловсруулан, 2016 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар Эрүүл мэндийн Стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлж дэмжигдсэн.</p> <p>“Микробиологийн сорьц тээвэрлэхэд тавигдах шаардлага” MNS: 6619:2016 стандартыг батлуулсан.</p>
30	<p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай 2016.04.22</p>	<p>21.4.Энэ хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлж болох бөгөөд нэмэлт үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэхтэй холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>	<p>Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсаны дагуу энэ хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлж болох бөгөөд нэмэлт үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэхтэй холбогдох журмын төслийг эрүүл мэндийн яаман дээр хэлэлцэж байна. Эрүүл мэндийн сайдын 2016 оны А228 тушаалаар нэмэлт үйлчилгээний жагсаалтыг баталсан.</p>
<p>Нийт 20 хуулийн 31 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна</p>			

**НИЙГМИЙН БОДЛОГО БОЛОВСРОЛ,СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНД ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	Төрөөс соёлын талаар баримтлах бодлого батлах тухай 2012.05.22 №02	2.2."Төрөөс соёлын талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх.	"Төрөөс соёлын талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах 2.4 тэрбум төгрөгийг 2016 оны төсөвт тусгасан.
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2013-02-07 №:20	1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн биелэлтийг хангах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбогдуулан дараах арга хэмжээг 2013 онд багтаан авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай: Их Хурлын даргын 2012 оны 103 дугаар захирамжаар байгуулсан барилгын тухай, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон барилгын тухай хууль тогтоомж, стандарт, норм ба дүрэм зөрчсөн, түүнчлэн зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан аж ахуйн нэгж, байгууллага, холбогдох этгээдийг нийтэд мэдээлэх, тэдгээрт хариуцлага тооцох;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрмийн хэрэгжилтийг барилгын салбарт эрчимжүүлэх тухай” албан даалгавар 01-ийг БХБ Сайдын 2012 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр батлуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг Барилгын салбарт хэрэгжүүлэхээр “Цэнхэр карт” сургалтын хөтөлбөрийг Барилга хот байгуулалтын сайд, Хөдөлмөрийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалалын сайд нарын хамтарсан 2013 оны 52/А/50/А/26 тоот тушаалаар баталсан. 2015 оны эхний хагас жилийн байдлаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг зөрчсөн болон үйлдвэрлэлийн осол гаргасан аж ахуйн нэгж байгууллагуудад хариуцлага тооцох арга хэмжээг тухай бүрд нь авч ажиллаж байна. Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлыг дээшлүүлэх зорилгоор “Ажлын байрны зааварчлага өгөх аргачилсан зөвлөмж” Барилгын дүрмийг БХБ Сайдын 2014-07 дугаар сарын 9-ний 113-р тушаалаар батлуулсан. “Бетон шахуургын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг БХБ Сайдын 2014 оны 07 дугаар сарын 09-ний 109-р тушаалаар батлуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн нэмэлт өөрчлөлт, Монгол Улсын Шадар сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар 2015 оны 06-р сарын 29-ний өдрийн 82;

			<p>141; 123 дугаар бүхий “Барилгын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах нийтлэг журам” батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад дээрх хууль, журмыг сурталчлах сургалтыг Хөдөлмөрийн яам, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-тай хамтран 2015 оны 7-р сарын 31, 8-р сарын 7, 14-ний өдрүүдэд зохион байгууллаа.</p> <p>Тус сургалтын хугацаанд нийт 250 орчим аж ахуйн нэгж байгууллагын инженер, ХАБЭА хариуцсан инженер, удирдлагууд хамрагдаж дээрх сэдвийн хүрээнд мэдээлэл авч харилцан санал солилцсон.</p> <p>Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг зөрчсөн болон үйлдвэрлэлийн осол гаргасан аж ахуйн нэгж байгууллагуудад хариуцлага тооцох арга хэмжээг тухай бүрд нь авч ажилласан.</p>
3	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2013.02.08 №:19</p>	<p>1.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт оношлох, нийгэмшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд нийгмийн хамгааллын, эрүүл мэндийн сэргээн засах үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судлан үзэж холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	<p>Улсын Их Хурлын тогтоол ХАХНХ-ын сайдын 2013 оны А/106 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан хүчин төгөлдөр мөрдөж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд суурилсан, Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг хангах суурь зарчимд тулгуурласан, хүний эрхийн зохицуулалтыг түлхүү тусгасан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль" боловсруулан Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 39-р хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн.</p> <p>2015 оны 11-р сарын 6-нд УИХ-д өргөн барьсны дагуу 2016.02.05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдлаа.</p> <p>Энэхүү хуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүл, хамт олны дунд эрт илрүүлж, хөгжүүлэх, чадвар алдалтыг боломжит түвшинд хүртэл сэргээн засах, тусламж үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх зохицуулалтыг бий болгохоор тусгасан.</p>
		<p>1.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг тусгай сургууль болон сэргээн засалтын бусад</p>	<p>Ерөнхий боловсролын тусгай сургуулийн хамран сургах тойрог тогтоох, аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар бүлэг ажиллуулах, элсэлтийг зохион байгуулах асуудлаар</p>

		<p>төрөлжсөн байгууллага эзэмшүүлэх ажлыг шинэчлэн зохион байгуулах;</p>	<p>Нийслэлийн Боловсролын Газартай хамтран 2015 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр А/31 “Хамран сургах тойрог тогтоох тухай” тушаалыг гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.</p> <p>Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхэд багачуудыг ерөнхий боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах зорилгоор нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийг хавсралтаар баталсан.</p> <p>Батлагдсан хамран сургах тойргийн дагуу 2015-2016 оны хичээлийн жилийн элсэлтийг зохион байгуулж ажиллахыг дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгож, 4 дүгээр сарын 10-аас 5 дугаар сарын 15-ны хооронд шинээр элсэн суралцах сурагчдыг бүртгэлд хамруулж нийт элсэгчдийн 77,3 хувь бүртгэлд ороод байна.</p> <p>Энэхүү хамран сургах тойрог тогтоох ажлын хүрээнд нийслэлд буй тусгай сургуулиудад дүүрэг, тойрог харгалзахгүйгээр тухайн хөгжлийн бэрхшээлээр нь хамруулах асуудал нээлттэй болсон болно.</p> <p>2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль батлагдсанаар Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт орж хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т “Тусгай сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байна” гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулиуд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяанд шилжсэн.</p>
		<p>1.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах чиглэлээр мэргэшэх дохионы хэлний багш, арга зүйч, эмч, согог зүйч зэргийг бэлтгэх зорилгоор нийт 20-оос доошгүй хүнийг жил бүр гэрээгээр, сургалтын төрийн сангийн зардлаар гадаадад сургах арга хэмжээ авах.</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах туршлагатай, туршлага хуримтлуулж байгаа 21 аймгийн Боловсролын газрын мэргэжилтэн болон сургууль, цэцэрлэгийн 105 багшийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах боломжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт мэргэжил дээшлүүлэх сургалтад;</p> <p>Тусгай сургууль, цэцэрлэгийн 282 багш, туслах багшийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэдлэг, ур</p>

			<p>чадварыг дээшлүүлэх сургалтад; 30 согог зүйч багшийг мэргэшүүлэх сургалтад хамруулан, зөвлөн туслах, харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн . 2014 онд Унгар Улс, ОХУ-д тус бүр 5 хүн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш мэргэжлээр суралцахаар болсон.</p> <p>АНУ-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй 2 хүний бакалаврын сургалтын төлбөрийг магистрын сургалтын зардлын жишгээр төрөөс бүрэн хариуцах шийдвэрийг 2015 онд гарган хэрэгжүүлж байна.</p> <p>Мөн 2015 онд Унгар, Польш улсад тусгай хэрэгцээт боловсролын багш мэргэжлээр бакалаврын сургалтад 4 оюутан сургах шийдвэр гаргасан байна.</p> <p>2016 онд Унгарт 1, Польш улсад 4 хүнийг тусгай хэрэгцээт боловсролын багш мэргэжлээр бакалаврын сургалтад сургахаар шийдвэр гарсан.</p>
		<p>1.9.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлж, зарцуулах, хянах эрхийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хороонд шилжүүлэх, үүнтэй холбогдуулан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм болон бусад холбогдох дүрэм, журмыг шинэчлэх;</p>	<p>Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийн дагуу Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогыг судлан бүртгэх эрүүл мэндийн байгууллагын орон тооны бус байнгын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.</p> <p>“Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан 150 иргэнд сургалт зохион байгуулсан.</p> <p>Өдөрлөгт аймаг болоод улсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын үзүүлэлтээр тэргүүний 11 аж ахуйн нэгж байгууллага оролцож хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сайн туршлага, үйл ажиллагааг олон нийтэд сурталчиллаа. Өдөрлөгт нийтдээ 85 байгууллагын 150 гаруй төлөөлөл оролцсон.</p>
4	<p>Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай 2014.10.09 №:57</p>	<p>2.1."Төрөөс эмийн талаар баримтлах бодлого"-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2014 оны 4 дүгээр улиралд багтаан батлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байшуулах,</p>	<p>Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 425 дугаар тушаалаар баталсан.</p> <p>Мөн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны төсвийн тооцоог Эрүүл мэнд спортын сайдын 2015 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 300 дугаар тушаалаар баталсан.</p>

		2.2"Төрөөс эмийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусган хэрэгжүүлэх.	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 425 дугаар тушаалаар баталсан. Мөн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны төсвийн тооцоог Эрүүл мэнд спортын сайдын 2015 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 300 дугаар тушаалаар баталсан.
5	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай 2015.01.29 №:12	2.2."Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-ын стратегийн зорилтыг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх.	Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын А/66 дугаар тушаалаар байгуулан, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-ын стратегийн зорилт бусад хууль тогтоомж, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан боловсруулсан. Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээний матриц, салбарын өнөөгийн байдал, арга хэмжээний танилцуулга зэргийг бэлтгэн 2016 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн 1/1176 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэн ажилласан.
Нийт 5 тогтоолын 9 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна.			

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ
ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p align="center">Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай</p> <p align="center">2013.04.16 №04/04</p>	<p>1.1.Сургалтын төрийн сангийн зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох, нийтэд мэдээлэх харилцааг зохицуулах журмыг шинэчлэн боловсруулж 2013 оны эхний хагас жилд багтаан гаргах,</p>	<p>1. Зээлийн ашиглалт 1993-2015 онд: Дотоодын их, дээд сургууль, коллежийн давхардсан тоогоор 160000 оюутанд 44,6 тэрбум төгрөг, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын бакалаврын хөтөлбөрт суралцаж буй 343 /давхардсан тоогоор/ оюутанд 14,011 ам доллар, мөн магистр, докторын хөтөлбөрт суралцагч 3489 /давхардсан тоогоор/ оюутанд 53,274 сая ам долларын зээлийг тус тус олгосон байна.</p> <p>2. Зээлийн эргэн төлөлт 1997-2015 онд: 2006 оноос өмнө дотоодын их, дээд сургууль коллежийн бакалаврт зээлээр суралцаж төгссөн иргэдийг Засгийн газрын 2004 оны №22, 2008 оны №178 дугаар тогтоолуудын дагуу зээлээс чөлөөлсөн ба тус оноос хойш суралцаж төгссөн бакалавр, магистрантур, докторантурыг төгсөгчдөөс 2013 онд 451 хүний 382,2 сая төгрөг, 2014 онд 553 хүний 344,7 сая төгрөг, 2015 онд 396 хүний 240,7 сая төгрөгийн зээл буюу нийт 1 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг улсын төсөвт төвлөрүүлсэн болно.</p> <p>Гадаадын дээд боловсролын сургалтын байгуулагад суралцаад төгсөж, гэрээний үүргээ биелүүлсэн төгсөгчдийг Засгийн газрын шийдвэрээр зээлээс чөлөөлж, тэдний гэрээний биелэлтийг дуусгавар болгож байна.</p> <p>Үүний дагуу гэрээний үүргээ биелүүлсэн төгсөгчдийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Иргэний хуулийн 238 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлийг үндэслэн 2013 онд 201 хүний 8,4 тэрбум төгрөг, 2014 онд 137 хүний 7,9 тэрбум төгрөг, 2015 онд 49 хүний 2,8 тэрбум төгрөгийн зээлийг чөлөөлсөн байна. 2016 онд БСШУ сайдын “Гэрээний биелэлтийг тооцон дуусгавар болгох тухай” А/260 дугаар</p>

		тушаалаар нийт 51 хүний 2.7 тэрбум төгрөгийн зээлийг чөлөөлсөн.
	1.10/. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2013 оны 10 дугаар сарын 01-ний дотор, цаашид жил бүрийн улсын төсвийн гүйцэтгэлийг УИХ-аар хэлэлцэх үед УИХ-ын нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон төсвийн байнгын хороонд тогтмол мэдээлж байх.	Дотоодын их, дээд сургууль, коллежийн давхардсан тоогоор 160000 оюутанд 44,6 тэрбум төгрөг, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын бакалаврын хөтөлбөрт суралцаж буй 343 /давхардсан тоогоор/ оюутанд 14,011 ам доллар, мөн магистр, докторын хөтөлбөрт суралцагч 3489 /давхардсан тоогоор/ оюутанд 53,274 сая ам долларын зээлийг тус тус олгосон бөгөөд мэдээллийг тухай бүр БСШУЯ болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Төсвийн байнгын хороодод тогтмол хүргүүлэн ажилласан байна.
	1.2/. Сургалтын төрийн сантай гэрээ байгуулан гадаадад суралцагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж эзэмшсэн мэргэжлээрээ төрийн байгууллагад 5 жил ажилласан бол зээлээс бүрмөсөн чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгож 2013 оны 7 дугаар сарын 01-нээс мөрдүүлэх.	2006 оноос өмнө дотоодын их, дээд сургууль коллежийн бакалаврт зээлээр суралцаж төгссөн иргэдийг Монгол Улсын Засгийн газрын 2004 оны №22, 2008 оны №178 дугаар тогтоолуудын дагуу зээлээс чөлөөлсөн ба тус оноос хойш суралцаж төгссөн бакалавр, магистрантур, докторантурыг төгсөгчдөөс 2013 онд 451 хүний 382,2 сая төгрөг, 2014 онд 553 хүний 344,7 сая төгрөг, 2015 онд 396 хүний 240,7 сая төгрөгийн зээл буюу нийт 1 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг улсын төсөвт төвлөрүүлсэн болно. Гадаадын дээд боловсролын сургалтын байгуулагад суралцаад төгсөж, гэрээний үүргээ биелүүлсэн төгсөгчдийг Засгийн газрын шийдвэрээр зээлээс чөлөөлж, тэдний гэрээний биелэлтийг дуусгавар болгож байна. Үүний дагуу гэрээний үүргээ биелүүлсэн төгсөгчдийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Иргэний хуулийн 238 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлийг үндэслэн 2013 онд 201 хүний 8,4 тэрбум төгрөг, 2014 онд 137 хүний 7,9 тэрбум төгрөг, 2015 онд 49 хүний 2,8 тэрбум төгрөгийн зээлийг чөлөөлсөн.
	1.6/Инженер технологийн чиглэлээр дэлхийд шатлалаараа 100-д багтдаг нэр хүндтэй их сургуулиудад төрөлхийн гоц авьяастай, улс, тив, дэлхийн	Инженер технологийн чиглэлээр дэлхийд шатлалаараа 100-д багтдаг нэр хүндтэй их сургуулиудад эхний гурван байрт орсон хүүхдүүдийг төрийн зардлаар сургахад тавих шалгуурыг хөнгөрүүлдэггүй бөгөөд Засгийн газрын 2013 оны

		<p>олимпиадуудад эхний гурван байрт орсон хүүхдүүдийг төрийн зардлаар сургахад тавих шалгуурыг хөнгөрүүлэхгүй байх, эдгээр авьяастай хүүхдүүдийг гадаад хэлний тусгайлсан бэлтгэлд хамруулж эдгээр сургуулиудад элсэх бэлтгэлийг хангах нөхцөлийг бүрдүүлж өгөх,</p> <p>1.7/Төрийн сангийн зээлийг мэргэжлийн ямар чиглэлээр олгох, зарцуулалт, эргэн төлөлтийн талаарх мэдээллийг ил тод нээлттэй болгон суралцахыг хүсэгчдэд мэдээлэл олгодог тусгай төв байгуулах,</p> <p>1.8/Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадын их, дээд сургууль болон магистрантур, докторантурт суралцуулах хүний тоо, мэргэжлийн чиглэлийг холбогдох яамдаас гаргуулан авч нийтэд мэдээлэх, захиалгын дагуу нийтэд нээлттэй шалгаруулан суралцуулах,</p>	<p>271 дүгээр тогтоолоор баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам” үйлчилж байна. Журамд тавигдах аливаа шалгуур, шаардлагууд нь нийт шалгуулагчдад тэгш боломжийг олгон тогтмолжсон байна.</p> <p>Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-д заасны дагуу дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах мэргэжлийн чиглэл, тухайн жилд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, ил тод байдлыг ханган ажиллаж байгаа бөгөөд Сургалтын төрийн сан нь сургалтын зээлээр суралцагчид болон тэдний суралцаж буй их сургуультай харилцан мэдээлэл солилцож, мэдээллийн сан бүрдүүлж, суралцагчдын нэр, сургууль, мэргэжлийн чиглэлийн талаарх мэдээллийг Сургалтын төрийн сангийн цахим хуудсанд байршуулж, мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-д заасны дагуу дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах мэргэжлийн чиглэл, тухайн жилд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, ил тод байдлыг ханган нээлттэй сонгон шалгаруулалтаар суралцуулах ажлыг тогтмол зохион байгуулж байна.</p>
2	<p>Эрүүл мэндийн даатгалын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай</p> <p>2013.10.16 №:07</p>	<p>4.Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг даатгуулагчийн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, хүн амын зонхилон тохиолдох өвчлөлийн байдалтай уялдуулан шинэчлэн тогтоох</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг даатгуулагчийн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, хүн амын зонхилон тохиолдох өвчлөлийн байдалтай уялдуулан шинэчлэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг даатгуулагчийн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, хүн амын зонхилон тохиолдох өвчлөлийн байдалтай</p>

			уялдуулан шинэчлэн тогтоож, эрүүл мэндийн даатгалын сангаас 183 нэр төрлийн 817 эмийг 40-80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож байгаа бөгөөд улсын хэмжээнд 762 эмийн сан хөнгөлөлттэй эмээр үйлчилж байна.
3	<p>Шинжлэх ухааны байгууллагуудыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай</p> <p>2014.04.23 №:07</p>	<p>2.Шинжлэх ухааны академи, түүний салбар академи, харьяа эрдэм шинжилгээний байгууллагуудын болон анагаах ухаан, хөдөө аж ахуйн салбарын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн санхүүгийн бие даасан байдлыг хангаж, хөгжиж буй орнуудын жишгээр эрдэм шинжилгээний зардлын хэмжээ, лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, хангамжийг сайжруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаадын төсөл, хөтөлбөрт хамруулах талаар дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Сүүлийн хоёр жилд УИХ-аас баталсан улсын төсөвт боловсрол, эрүүл мэндийн салбараас бусад салбарын их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг тэглэсэнтэй холбоотойгоор шинжлэх ухааны салбарт дорвитой хөрөнгө оруулалт хийгдээгүй. Иймээс төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагуудын лаборатори, техник, тоног төхөөрөмж ихээхэн хоцрогдож байна.</p> <p>Монголдоо олон улсын түвшинд жишигт хүрсэн лаборатори, тоног төхөөрөмжид суурилан судалгааны ажил хийх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд 30 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт тэргүүн ээлжинд шаардлагатай байна. Энэ зорилтын хүрээнд шинжлэх ухааны салбарт төрөөс оруулж буй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, 2017-2018 онд 41.3 тэрбум төгрөгт хүргэх шаардлагатай.</p> <p>Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр төрийн өмчит 10 шахам их сургуулиудад 2014-2015 онд 10 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, тэдгээрийн лабораторийн орчин, судалгаа, шинжилгээний баазыг өргөтгөсөн.</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам эхний ээлжинд нэн шаардлагатай байгаа лабораторийн тоног төхөөрөмжөөр эрдэм шинжилгээний байгууллагуудыг хангах төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2017 онд лабораторийн орчин нөхцлийг сайжруулахад 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, судалгаа боловсруулалтын ажилд 10,3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж байна.</p>
		<p>4.Эрдэм шинжилгээний байгууллагуудын дэргэд гарааны компани байгуулах боломж олгох чиглэлээр төсвийн болон компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинжлэх ухаан, технологийн үндэсний парк байгуулах ажлын явцыг эрчимжүүлэх.</p>	<p>“Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн”198.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам”-ыг Засгийн газрын 2014 оны 11 дүгээр сарын 26-ны 374 дүгээр тогтоолоор батлууллаа.</p> <p>Энэхүү журам нь эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн дэргэд гарааны компани байгуулах, бүртгүүлэх,</p>

			<p>үйл ажиллагааг дуусгавар болгохтой холбоотой нийтлэг харилцааг зохицуулна.</p> <p>Журам батлагдсанаар эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулан ажиллуулах замаар эрдэмтэн судлаачдын бүтээсэн оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, инноваци, өндөр, технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэс суурийг тавихад чухал ач холбогдолтой болж байна.</p> <p>Инновацийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 2015, 2016 онуудад их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулахаар ирсэн хүсэлтүүдээс 32 материалыг шаардлага хангасан гэж үзсэн тул эдгээр “Гарааны” 32 компани Улсын бүртгэлд албан ёсоор бүртгэгдэн, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.</p> <p>Эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгжүүд хамтран инновацийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах орчин, дэд бүтцийг бүрдүүлэх, импортыг орлох болон экспортод чиглэсэн өндөр технологи, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих үүрэг бүхий “Шинжлэх ухааны паркийн захиргаа”-г байгуулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p>
		<p>6. Засгийн газрын тусгай сангийн тухай хуультай уялдуулан шинжлэх ухаан, технологийн сангийн чиг үүргийг өргөтгөж, сангийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтыг оновчтой болгох, ашиглалтыг сайжруулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэлд нэвтрүүлэх хөшүүрэг бий болгох.</p>	<p>Засгийн газрын 2014 оны 135 дугаар тогтоолоор Шинжлэх ухаан, технологийн санг шинжлэх ухаан, технологийг салбарын төсвийн төвлөрүүлэн захирагч болгох батлуулсан.</p> <p>Ингэснээр санхүүжилтийн хуваарилалт, зарцуулалтыг оновчтой төлөвлөх бололцоо нээгдсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газар 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль”-д үндэслэн хувийн хэвшлийн оролцоонд тулгуурласан Хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулж, инновацийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх тааламжтай бүтцийг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.</p> <p>Уг зорилтыг биелүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтарсан хэлбэрээр инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулах санал боловсруулах ажлыг 2017</p>

			<p>онд хийхээр төлөвлөж байна.</p> <p>Мөн Шинжлэх ухаан, технологийн сангийн бүтцийг хууль, тогтоомжид нийцүүлэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/48 дугаар тушаалаар батлууллаа.</p> <p>Шинээр батлагдсан бүтцийн дагуу Шинжлэх ухаан, технологийн сан нь Санхүү, удирдлагын хэлтэс, Мэдээллийн сан, мониторингийн хэлтэс, Шинжлэх ухааны паркийн менежментийн хэлтэс гэсэн нэгжтэйгээр ажиллаж байна.</p>
		<p>7.Хамтарсан төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, магистр, докторын сургалт, судалгааны хөтөлбөрийн үйл ажиллагаанд эрдэмтэд судлаачдыг оролцуулах, лабораторийн нөөц боломжийг хамтран ашиглах чиглэлээр шинжлэх ухааны академи, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд болон их сургуулиудын үйл ажиллагааны уялдаа холбоог тодорхой болгож хэрэгжүүлэх.</p>	<p>БСШУСЯ 14 дээд боловсролын сургалтын байгууллагаас Дээд боловсролын сургалтын байгууллага ба үйлдвэрлэлийн түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр ирүүлсэн 63 төслийн саналыг хүлээн авч, БСШУ-ны сайдын А/50 дугаар тушаалаар баталсан журмын шалгуур үзүүлэлтээр шинжээч томилон ажиллууллаа.</p> <p>7 их, дээд сургуулийн 16 төслийг сонгон шалгаруулж, АХБ-нд холбогдох зөвшөөрлийг авахаар хүргүүлсэн.</p> <p>АХБ-аас 13 төслийг дэмжсэн хариу ирүүлсэн ба БСШУС-ын сайдын 2016 оны 9-р сарын 09-ний А/26 дугаар тушаалаар баталгаажуулан, 13 төслийг 485 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн болно. БСШУСЯ болон төсөл гүйцэтгэгч байгууллага хооронд хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны “Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах тухай” А/56 тушаалаар залуу эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах хуваарь болон шаардагдах зардлыг баталсан.</p> <p>Эрдэм шинжилгээний бага хурал 2016 оны 10 дугаар сарын 14-29-ний өдрүүдэд Дархан болон Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа. Уг хурал нь залуу судлаач, эрдэмтэд, багш нар эрдэм шинжилгээнийхээ ажлын үр дүнг харилцан мэдээлэх, шүүн хэлэлцүүлэх, шинжлэх ухаан технологийн шинэлэг үр дүн, ололт амжилтаас харилцан суралцах, эрдэм шинжилгээний ажлын арга зүйн мэдлэг, түвшинг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ юм.</p> <p>Шинжлэх ухааны 6 салбараас эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж шалгарсан шилдэг 12 залуу судлаач тус бүрт</p>

			<p>олгох Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын нэрэмжит 4 сая төгрөгийн судалгааны грантыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны “Грант олгох тухай” А/112 тоот тушаалаар баталгаажуулан, 11 дүгээр сарын 25-ны өдөр олгосон.</p> <p>2016 оны докторын дараах судалгааны тэтгэлэг олгох арга хэмжээг БСШУ-ы сайдын 2012 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэг олгох" журмын дагуу зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад тэнцсэн шилдэг 10 залуу эрдэмтэнд нэрэмжит тэтгэлгийг олгосон.</p> <p>Тэтгэлгийн хэмжээ нь 10 сая төгрөг бөгөөд 45 хүртэлх насны залуу эрдэмтэнд олгодог уламжлалтай. 2010 оноос хойш 66 шилдэг залуу судлаачид энэхүү тэтгэлгийг хүртээд байна.</p> <p>Уг тэтгэлэг нь залуу эрдэмтдийн судалгааны ажлын чанарыг дээшлүүлэх, үр дүнг инноваци болгох, эрдэмтдийн залуу халааг бэлтгэх, оюуны өмчөөр баталгаажсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход чиглэгддэг.</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны 02 сарын 26-ны “Журам батлах тухай” А/65 дугаар тушаалын хавсралтаар их, дээд сургуулийн “Магистрант, докторантад судалгааны тэтгэлэг олгох журам”-ыг батлуулсан.</p> <p>Журмаар Шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэлээр их, дээд сургуулиудад магистрант, докторантад сурч буй залуу судлаачдад тэтгэлэг олгох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан.</p> <p>Их, дээд сургуулиудын интерпренёр үйл ажиллагааг дэмжих, эрдэмтэн судлаачдын залуу халааг бэлтгэх, тэдний эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажлын үр өгөөжийг нь дээшлүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.</p> <p>Энэхүү тэтгэлэгт их, дээд сургуульд суралцан, эрдэм шинжилгээ, туршилтын ажил идэвхитэй гүйцэтгэж байгаа магистрант болон докторантууд хамрагдах боломжтой.</p> <p>Өөрийн судалгааны чиглэлээр төсөл бичиж, сонгон шалгаруулалтад тэнцсэн 10 хүртэлх магистрантын судалгааны ажилд тус бүр 5 /тав/ сая хүртэл, 5 хүртэлх докторантын судалгааны ажилд тус бүр 10 /арав/ сая хүртэл төгрөгийн тэтгэлэг олгох юм.</p>
--	--	--	--

4	Эмнэлгийн барилга, эзэмшил газрын талаар цаашид авах арга хэмжээний тухай 2014.05.13 №:09	2. Улсын төсвөөс санхүүжүүлэхээр өмнөх оны төсвийн тухай хуулинд тусгагдсан боловч үлдэгдэл болон нэмэлт санхүүжилт, техникийн нөхцөл шийдвэрлэгдээгүйн улмаас дуусаагүй барилгыг төсвийн болон төсвийн бусад эх үүсвэрээр/эмнэлгийн зориулалтаар бүхлээр нь болон хэсэгчлэн дуудлага худалдаанд оруулах, концессийн гэрээ, төр хувийн хэвшлийн түншлэл/ашиглалтад оруулах;	300 ортой төрөх эмнэлгийн барилгын ажлыг Засгийн газрын тогтоолоор концессийн гэрээгээр гүйцэтгүүлэх болсон. Үндэсний хөгжлийн газарт уг барилгын үлдэгдэл өртөгийг тооцоолох ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Засгийн газрын тогтоолын дагуу хэрэгжээгүй, шинээр эхлэх барилгын ажлыг санхүүжүүлээгүй. Царцаагдсан болон урьд нь хэрэгжиж эхэлсэн ажлын санхүүжилтийг 2017 оны төсөвт тусгасан.
		3.Барилга захиалагчийн албанаас угсралтын ажлын үе шат бүрт тавих хяналтыг сайжруулах, гэрээний биелэлтийг хангуулах, төсөвт өртгөө үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, хуурамч гүйцэтгэл гаргаж санхүүжилт авсан аж ахуйн нэгж, албан байгууллагатай хийсэн гэрээг цуцлах, хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх,энэ ажилд тухайн орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоог хангах	Засгийн газрын 93 дугаар тогтоолын дагуу барилга угсралт, их засварын ажлыг Барилгын хөгжлийн төвөөр гүйцэтгэлийг хянуулж, Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу он жил дараалан төсөвт өртөг нэмэгдсэн ажилд магадлын ерөнхий дүгнэлт гаргуулсан. Гүйцэтгэгчийн буруутай үйлдлээс болж хэрэгжээгүй ажлын гүйцэтгэгчийг хууль хяналтын байгууллагад өгсөн.
		4.Эрүүл мэндийн салбарт баригдах барилгын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг мэргэшсэн байгууллагаар хийлгэх, олон улсын эмнэлгийн жишигт хүрэхүйц байдлаар төлөвлөх	Эрүүл мэндийн салбарт 10 орт, 14 орт, 15 орт, 22 орт, 50, 100, нэгдсэн эмнэлэг, уламжлалт анагаах, эмийн сан, халдварт өвчин, зооноз зэрэг эмнэлгийн барилгын нэг хэв маягийн 15 зураг, төсвийг хийлгэн батлуулсан.
5	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016.03.26 №09/03	10.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комиссыг хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны харьяанд ажиллуулах,	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.3-д Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс нь хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана гэсэн заалтын дагуу уг комисс 2016 оны 09 дүгээр сараас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын эрхлэх асуудалд хамаарч, холбогдох асуудлыг хариуцсан 3 мэргэжилтэн ажиллаж байна.

		<p>11.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв болон салбар комиссын гишүүдийн бүрэлдэхүүнийг оновчтой сонгож, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллуулах</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн төслийг боловсруулах ажлын хэсэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А206 тоот тушаалаар байгуулагдан ажиллав.</p> <p>Уг дүрмийн төслийг холбогдох яамд, төрийн болон төрийн бус байгууллагуудаар хэлэлцүүлэн саналыг авч тусган сайжруулах ажлыг зохион байгуулав.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 200 дугаар тогтоолоор батлагдав.</p>
		<p>12. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв болон салбар комиссын үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг Монгол Улсын 2016 оны төсвийн тодотголын төсөлд тусган, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	<p>2016 онд “БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдах "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Хөгжлийн төвийн барилга"-ын Монголын тал хариуцах гадна шугам сүлжээний зардал, зураг төсөл, /Улаанбаатар, Баянгол дүүрэг/" арга хэмжээнд 1857.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон.</p> <p>Салбар комисст шаардагдах хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний 2016 оны төсвийн багцад тусгасан. Салбар комиссын гишүүдийн ажилласан цагийн тооцоог гаргаж, нийт 9 салбар комисс /Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Ховд, Орхон аймаг, Баянгол дүүрэг/-ын гишүүдэд 1-6 сарын нэмэгдэл хөлс болох 24,640,644 төгрөг, 7-11 сарын нэмэгдэл хөлс болох 16,663,354 төгрөгийг Төрийн сангаар дамжуулан тус тус олгосон.</p>
		<p>13.Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн үдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх, шаардагдах санхүүжилтийг улсын төсвөөс санхүүжүүлэх</p>	<p>2016 онд “Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 70 дугаар тусгай сургууль/” төсөл, арга хэмжэнд үлдэгдэл 51.9 сая төгрөгийг векселиэр олгосон.</p>
		<p>6.Тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгийн чиг үүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдийн хамт сургаж, хөгжүүлж байгаа төрийн болон төрийн бус өмчийн сургалтын байгууллагуудад мэргэжил</p>	<p>Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Бага, дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн холбогдох заалтад энэ талаар тусган хэрэгжүүлж байна.</p>

		арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийг нэмж оруулах,	
		8.Ерөнхий боловсролын тусгай сургуулиуд дэргэдээ сургалт, үйлдвэрлэл, дадлагын аж ахуйтай байхыг дэмжих	Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Бага,дунд боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд энэ асуудлыг тусгасан бөгөөд хэрэгжүүлэн ажиллаж байна.
6	<p>Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай</p> <p>2016.04.05 №:10</p>	<p>1.4. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, хдхв/дох-оос урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг МҮОНРТ, боловсрол суваг болон бусад радио, телевиз, сонин хэвлэл, нийгмийн сүлжээг ашиглан хүн амын дунд зохион байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх;</p>	<p>Дэлхий нийтээрээ жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийг ДОХ-ын эсрэг олон нийтийн анхаарал хандуулах өдөр болгон тэмдэглэдэг бөгөөд Монгол Улсад төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран тэмдэглэсээр 20 гаруй жил болж байна.</p> <p>2016 онд “Хүний дархлал хомсдлын вирус, Дархлалын олдмол хомсдлоос сэргийлэх нь та бидний гарт” гэсэн уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн. Тус арга хэмжээг</p> <ul style="list-style-type: none"> -Ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургуулиудын эрүүл мэндийн ажилтнуудаар дамжуулан, өсвөр үеийнхэн, оюутан залуучуудад мэдээлэл түгээх, -Халдварт өвчин судлалын үндэсний төв дээр ажилладаг “Улаан тууз” эмнэлэг 12 дугаар сарын 1, 2-ны өдрүүд уртасгасан цагаар ажиллаж, шинжилгээ хийж, зөвлөгөө өгөх, -ХДХВ, ДОХ-ын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжих, дуу хоолойг нийтэд хүргэх, -Хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж, урьдчилан сэргийлэх талаар нэгдсэн мэдээллийг түгээх зэргээр төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог ханган улс даяар тэмдэглэсэн. <p>Нийт 17 хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид 26 удаа мэдээлэл хийсэн байна.</p> <p>Жил бүр 5-р сарын 17 нд ЛГБТ хүмүүсийг үзэн ядахын эсрэг өдөрт зориулж, нэвтрүүлэг хийж байсан, Мөн “Хязгааргүй” нэртэй богино хэмжээний цуврал кино хийж хүмүүст хүргэж бна. 2016 оны 12 дугаар сарын байдлаар 2 анги нь хийгдэж олны хүртээл болсон.</p>
		1.8. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогчдын зүгээс	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14, 25 дугаар зүйлийн дагуу ажил олгогч нарыг ажиллагсдыг эрүүл мэнийн үзлэгт тогмтол хамруулж байх талаар заасан

		ажиллагсдаа сүрьеэ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах,	байна. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогчдын зүгээс албан хаагчдаа сүрьеэ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж, ажиллах талаар чиглэл өгч, УИХ-ын НББСШУБХ-ны тогтоолыг албан тоотоор хүргүүлсэн ажиллаж байна.
Нийт 6 тогтоолын 23 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна.			